

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ  
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 12 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон бөгөөд үүнтэй холбогдуулан “Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу жилийн төсвийн төслийг Засгийн газар дахин боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, төсвийн төсөлд тусгах өөрчлөлтийн хүрээг тусгасан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд Засгийн газраас жилийн төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн мэдүүлэхдээ төсвийн төслийн танилцуулга, тооцоолол, судалгааг Төсвийн тухай хуулийн дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсөвт үндэслэн боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тусгасан байх бөгөөд төсвийн нийт зарлага, алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төслийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны төсвийн төслийг дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батлах өөрчлөлтийг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн аймаг, нийслэл, сум, дүүрэг тухайн шатны төсвийн


төслийг батлах цаглаврын талаар болон төсвийг буцаасан тохиолдолд Засгийн газар дахин өргөн мэдүүлж, батлах үндэслэлийг хуулийг хүчингүй болгохоос бусад бүх нөхцөлийг тусгах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар жилийн төсөвт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тохиолдолд Улсын Их Хурал төсвийг дахин хэлэлцэх дэгийн зохицуулалтыг бий болгох, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд төсвийн төслийг Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны төсвийн төслийг батлах цаглаврыг нарийвчлан тооцох, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Заяабал нар жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах зохицуулалтыг боловсронгуй болгох талаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах нь зүйтэй талаар асуулт асууж, үг хэлсэн бөгөөд Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ц.ДАВААСҮРЭН**